

Бүгд найрамдах Казакстан улсын Аль-Фарабийн нэрэмжит их сургууль бол зөвхөн тус улсын биш үүнээс гадна Дунд Ази болон бүхэл Турк угсаатны боловсрол, шинжлэх ухааны гал голомт юм. Тус их сургуульд БНКУ-ын төгсөгчдөөс гадна, дэлхийд тархан суурьшсан бүх Казах залуучууд сурахыг туйлын их хүсдэг гэдэг нь элсэн суралцах гориллогчдын дунд явуулсан судалгаагаар батлагдаж байна.

Хүссэн мэргэжлээрээ суралцахын тулд гадаад улс орнуудаас ирсэн оюутнууд ч гэсэн элсэлтийн ерөнхий шалгалт өгөх ёстой. Учир нь зарим улс орнуудын ерөнхий боловсролын систем эрс ялгаатай, түүнчлэн гадаад орнуудаас ирсэн оюутнууд казах ардын үндэсний түүх, соёл, хэл г.м үнэт зүйлүүдийн талаар огт ойлголтгүй ирдэг болохоор суралцахад зохих хэмжээний хүндрэл учирдаг. Тиймээс гадаад орнуудаас ирсэн төгсөгчдийг эхлээд бэлтгэл ангид оруулах уламжлалтай.

АЛЬ-ФАРАБИЙН НЭРЭМЖИТ КАЗАХСТАН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ ХАМГИЙН ШИЛДЭГ НЬ

Бэлтгэл ангийн тэнхим янз бүрийн орнуудаас ирсэн суралцагчдад зориулан мэргэжлийн өндөр түвшний сургалт явуулахаас гадна зөв хүмүүжил олгох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах гэх мэт ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор «Жас талап», «Жауказын» нэртэй дугуйлангууд ажиллуулж эхэлжээ. Уг тэнхим нь 2022-2023 оны шинэ хичээлийн жилд Казакстан улсын сургалтын систем нь олон улсын сургалтын системтэй өрсөлдөх чадвартай, тус улсад үйл ажиллагаа явуулдаг бусад их, дээд сургуулиудаас ч гэсэн сургалтын чанар, зохион байгуулах чадвараараа «Тэргүүлэх их сургууль» гэдгийг таниулахыг зорьж байгаа болно. Хамт олноо хандлагыг өөрчлөх, чадваржуулах, сурагчдаа хөгжүүлэх гэсэн зорилгын хүрээнд сургуулийнхаа материаллаг баазыг бэхжүүлж, номын сан, сургуулийн гадаад болон дотоод орчин, дотуур байрны сурагчдыг тав тухтай, тохилог дулаан орчинд сурч боловсрох орчныг бүрдүүлж, аюулгүй, сэтгэл ханамжтай үйлчилгээ бий болгох бүх бололцоог бүрэн хангаж ажиллаж байна. Бүгд Найрамдах Казакстан улсын иргэдийн оюуны чадамж өндөр байгааг илтгэх, эдийн засаг нь маш хурдацтай хөгжиж буй улс орны хувьд хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтод гүн хүндэтгэлтэй ханддаг улс гэдгийг баглах, түүнээс гадна Казах ард түмний оюун санаанд тогтсон эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийн талаарх гадаадаас ирсэн суралцагчдад ойлголт өгөх, тэд нарын манай улсын талаар буруу зөрүү үзэл бодлыг эергээр өөрчлөх зорилгоор янз бүрийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Үүний нэг нь «Атамекен – алтын бесік» (Эх орон - алтан эрдэнэ) (холбогдох мэдээллүүд <https://www.kaznu.kz> сайтад байршуулсан болно) нэртэй соёлын арга хэмжээ юм. Бүгд найрамдах Казакстан улсын гэрэлтэй ирээдүй – боловсролтой, мэдлэгтэй, дэлхийн шинжлэх ухааны орон зай болон хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай залуучуудын гарт байна. Өнөөгийн боловсролтой, мэдлэгтэй залуус маань ирээдүйн мэдлэгтэй мэргэжилтэн, шилдэг боловсон хүчин юм.

Одоо тэд маань нийгмийн хариуцлагыг үүрэх ээлж нь нэгэнтэй ирсэн. Харин энэ бүх хариуцлагыг багш хүн биеэрээ мэдэрч өөрөө зөв хандлагатай зөв хүн болж төлөвшиж, эрдэм мэдлэгтэй, хийж байгаа зүйлдээ эзэн ёсоор ханддаг төлөвшсөн мэргэжилтэн бэлтгэх ёстой. Энэхүү эрхэм зорилгынхаа хүрээнд манай тэнхимийн казах хэл, уран зохиолын ахмад багш Р.Т.Наралиеваар ахлуулсан ажлын хэсэг тэнхимийн дэргэд «Жас талап» нэртэй дугуйлан зохион байгуулав. Тус клуб нь аливаа улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны боловсролын стандарт, их сургуулийн дүрэмд нийцүүлэн ажлаа зохион байгуулахаас гадна эх орныхоо энх тайвныг эрхэмлэгч зан чанарыг сурталчлах, суралцагч бүрийг өөрийн чадварт тохируулан хувь хүн болоход нь туслах мэргэжлийн чиг баримжаа олгох хичээллүүдийг явуулдаг. Дугуйлан, клубын нээлтийн үйл ажиллагаа мэргэжлийн чиг баримжаа олгох «Мэргэжил бүхэн сайхан» нэртэй виртуал хичээлийг зохион байгуулснаар эхэлнэ. Учир нь манай улсад боловсрол эзэмшихээр ирсэн гадаадын иргэд юуны түрүүнд бэлтгэл ангид хэлний бэлтгэлийн зэрэгцээ сонгосон мэргэжлийнхээ үндсэн хичээлээр суралцдаг. Суралцагчдад мэргэжлийнхээ талаар үнэн зөв мэдээлэл олж авснаар тус ажлын онцлог болон тэргүүлэх ач холбогдлыг сайтаар ойлгож, залуучуудын мэргэжлээ зөв сонгоход чийг баримжаа, тус дэм болно гэж үзэж байна. Үүний зэрэгцээ манай клуб нь залуучуудын бүтээлч чадварыг хөгжүүлэх, бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухааны судалгаанд суурилан, бие даан ажиллахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ зорилгоор сонирхолтой хичээллүүд, сургалт-семинар, асуулт хариулт танин мэдэхүйн тэмцээн, уралдаанууд - брейн-ринг, бүтээлч уралдаануудыг удаа дараа зохион байгуулж ирсэн. Манай дугуйлангийн уриа: "Залуу үе, Унш, сур, хөдөлмөрлө!". Мөн "Бидний дунд хоцрогдол байхгүй" уриан доор тус тэнхим нь оюутнуудын хоцрогдол арилгахад чиглэсэн нэмэлт ажлуудыг давхар хийдгээр онцлогтой. Мэдээж хүмүүжлээс ангид боловсрол дангаараа чанартай, үр өгөөжтэй байдаггүй гэдгийг бид бүгд мэднэ. Тиймээс тус дугуйлан нь оюутан суралцагчдын хүмүүжил, соёл болон боловсролын чанарыг хослуулан үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ зорилгынхоо хүрээнд "Ном - алтан эрдэнэ" («Кітап – алтын казына»), "Хэл бол хүмүүжлийн эхлэл" («Тэрбие басы – тіл»), "Аялал бол үндэсний оюун санааны үндэс", («Саяткерлік – ұлттық рухтың негізі») "Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалъя" («Табиғат-ананды аяла») нэртэй соёл, танин мэдэхүйн аялал, мэргэжлийн чиг баримжаа олгох хичээллүүдийг зохион байгуулж байна.

Манай бэлтгэл ангийн оюутнууд сургуулийн зүгээс зохион байгуулагддаг аливаа тэмцээн уралдаанаас гадна улсын хэмжээнд болон хотын хэмжээнд тэр ч байтугай олон улсын хэмжээнд зохион явуулдаг боловсролын уралдаан, төрөлжсөн хичээллүүдийн олимпиадад оролцож удаа дараа шагналт байрт шалгарч байсан. Түүнчлэн оюутнуудын дунд явуулдаг эрдэм шинжилгээний бага хуралд оролцох хүсэлтэй суралцагчдад эрдэмтдийн зөвлөлөөс чиглэл, зөвлөмж өгч тусалцаа үзүүлдэг.

Аль-Фарабийн нэрэмжит Казакстан улсын их сургуулийн бэлтгэл тэнхимийн багш нар: Наралиева Р.Т., Бегалиева А.К.

Мартагдашгүй оюутан, залуу нас

Мөнх цааст сүрлэг өндөр уулсаар хүрээлэгдсэн Алатаугийн энгэрт орших КазНУ хотхон түмэн олон залуусын оюутны амьдралын хамгийн хөгжилтэй, адармаатай бас адал явдалтай, дурсамж, сорилтуудыг сэтгэл дотроо хадгалж байгаа юм шиг дүнхийн харагдана. Энэхүү романтикаар дүүрэн Аль-Фарабийн нэрэмжит Казакстан улсын их сургуульд гадаадаас элэг нэгтэй ахан дүүс болох казах залуус маань ч суралцахаар зорин ирдэг. Гадаадаас ирсэн казах залуус боловсролын анхны гараагаа их сургуулийн өмнөх боловсролын тэнхимийн бэлтгэл ангид суралцахаар эхэлдэг. Аль-Фарабийн нэрэмжит Казак улсын их сургууль нь дээд боловсролын сургууль хүртэлх бэлтгэлийн ангийг /Дэлгэрэнгүй мэдээллийг сайтаас үзнэ үү/ Казакстаны их, дээд сургуульд «Болон» хөтөлбөрийн дагуу суралцах хүсэлтэй гадаадын иргэд, бас ЭИШ шалгалтад бэлтгэгдэхээр ирсэн гадаад улсад суугаа казах залуучууд болон, тус улсын залуучууд төлбөртэй тэнхимд ч гэсэн боловсрол эзэмших нөхцөл байдлыг бүрдүүлсэн болно. Тэнхимийн багш нарын хамт олон бэлтгэл ангийн сонсогчид болон залуучуудад чанартай боловсрол эзэмшүүлэхээс гадна хүмүүжлийн ажлыг бас давхар явуулна. Ердөө л 9 сарын дотор богинохон хугацаанд боловсрол эзэмшдэг ч гэсэн тухайн үед сонсогч нарын цаг хугацаагаа маш сонирхолтой явуулах нөхцөл байдлыг бүрдүүлж ажиллана.

Суралцагчид тэнхим болон сургуулийн зүгээс зохион байгуулагдах аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог оролцогтой. Үр дүнд нь улсын болон олон улсын түвшинд зохион байгуулагдах спорт, урлаг болон хичээлийн төрөлжсөн олимпиадууд, шилдэг бүтээл шалгаруулах тэмцээн уралдаанд оролцож удаа дараа шагналт байранд шалгарч байгаа. Тэнхим «Казакстанд тавтай морил», «Эх орон – нандин эрдэнэ», «Тусгаар тогтнол үнэт зүйл», «Бүх дэлхийн баяр», «Сайн байн уу Аз-Наурыз» гэх

мэт Казак улсын үндэсний баяр болон мөн орон орны баярууд, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан албан ёсны үйл ажиллагаа, урлагийн хөтөлбөрүүд зохион байгуулагддаг. Түүнчлэн суралцагчдыг тус улсын Туркистан, Тараз гэм мэт эртний баялаг тvvхтэй, тvvх дурсгалт хотууд болон байгалийн үзэсгэлэнтэй газрууд болох «Шарын хавцал», «Есик нуур», «Түргэний хүрхрээ», «Медеу мөсөн гулгуурын талбай» «Көктөбе», «Шынбулак» «Хайын нуур» г.м газруудаар аялуулдаг уламжлалтай.

Тусгаар тогтносон Казакстан улсын өнөөгийн улс төр болон нийгмийн аж байдал болон уламжлалт өв соёлд дасан зохицоход туслах, үндэсний үнэт зүйлүүдийг сурталчлан таниулах, түүнийг хүндэтгүүлэх зорилгоор нийгмийн хүмүүжил нэвт шингэсэн үйл ажиллагаанууд болон сонсогчдыг боловсрол шинжлэх ухааны замд хөтлүүлдэг эрдэм шинжилгээний семинарууд, вебинарууд, залуу эрдэмтдийн эрдэм шинжилгээний бага хуралууд зохион байгуулагдана.

Энэ оны сургалтын жилд гадаадаас ирж суралцагчдад зориулж улсынхаа үзэсгэлэнт Алмата хотыг танилцуулах, соёлын болон танин мэдэхүйн аялал жуулчлалын хичээл болон цайлган сэтгэлтэй казах түмний зочломтгой болон тусархаг сэтгэлийг, үндэсний соёлыг, хөгжин дэвших амьдрал ахуйдаа гүнзгий танилцуулах зорилгоор тус улсын Тусгаар тогтнолын өдөрт зориулж «Казакстанд тавтай морилон уу!» гэсэн баярын үйл ажиллагаа зохион явуулсан.

Энэхүү үйл ажиллагааг тус сургуулийн тэнхимийн эрхлэгч нарын санаачлаагаар их сургуулийн дэргэдэх бэлтгэл ангийн багш нар зохион явуулсан нь сайшаалтай хэрэг. Мөн шинээр элсэн орсон оюутнуудын дунд «Танилцах үдэшлэг» зохион байгуулж, амьдралын их далайд анхны алхмаа хийж их сургуульд элсэн орж оюутан хэмээх нэр зүүсэн залуучуудыг урмаар тэтгэж, тэдний оюутны амьдралын анхны өдрийг хөгжилтэй бас дурсамжтай өнгөрүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч ажилладаг юм.

Аль-Фарабийн нэрэмжит Казакстан улсын их сургуулийн бэлтгэл тэнхимийн багш нар: Наралиева Р.Т., Бегалиева А.К.

АМАНАТҚА АДАЛДЫҚ

Адамзат баласының алдында зор міндеттер түр. Ол Жерді қорғау, Бейбітшілікті сақтау және Руханиятты өлтірмеу. Бұл - эр елдің, эр халықтың перзентіне аманат. Біз де өз аманатымызға адалмыз, қолдан келгенше көздің қарашығындай қорғаймыз. Қазақ тілі, өнері, дәстүрі – қазақ елінің жаны, намысы, өмірінің мәңгілік мәні. Әлемнің қай түкпірінде болса да қазақ сол рухпен өседі, арман мақсаттарына талпынады, өмір сүріп, болашағына қанат қағады. Бұл қастерлі қасиеттерді өзім дәріс беріп келе жатқан университеттің шетелден келген қазақ балаларының бойынан көріп, көзім жеткен соң солай айтып отырмын. Қазақ, шын мәнінде, қай жерде жүрсе де қазақ екенін ұмытпайтын, рухын өлтірмейтін, намысын түсірмейтін ел екенімізді мақтан тұтамыз. Тілдің ұлтпен бірге біге қайнаған біртұтас тамыры. Олай дейтінім, эл-Фараби атындағы Қазақ Ұлттық университетінің <https://www.kaznu.kz> жоғары оқу орнына дейінгі білім беру факультетіндегі жоғары оқу орнына дейінгі дайындық кафедрасына жыл өткен сайын таланттары тасыған, талаптары таудай, өнерлі жастарымыз Атамекенге келіп, біздің осы ұлттық құндылықтарымызды дамытып қана қоймай, әлемнің эр түкпірінде насихаттап та жүргені, ұлттың жаршысы боп жүргендеріне алғысымыз шексіз. Биылғы оқу жылының басталғанына көп уақыт өте қоймаса да, елдің руханиятын асқақтатып біздің шәкірттеріміз өнер додасына да, білім сайысына да белсене кірісіп кетті. Университеттегі «Фараби фест» өнер байқауының бас жүлдесін Монғолиядан келген биші қызымыз Хайрол Ақгүл жеңіп алса, Әбдіхалел Бейбіт жүлделі екінші орынға ие болды. Ұлттық өнерімізді нақышына келтіріп, көрермен көзайымына айналып отыр, биіктерден көріне беріндер деп ақ батамызды беріп жатырмыз.

Сондай-ақ, ұлт ұстазы Ахмет Байтұрсынұлының 150 жылдық мерейтойына арналған «Отандастар қоры» ұйымының бәйгесіне шығармашылық топтан қатысқан Көгершін Амантай мен Арайлым Серікболдың өнерін элеуметтік желіден көрсеніңдер болады. Өлең оқу мәнері, тіл тазалығы, ішкі рухани дүниеге деген құштарлық осы жап- жас балаларымызда қанмен сінген қасиет екенін тағы бір танытты. Ұлы Аханың кісілік келбетін, ұлт жолында өмірін қиған асыл азаматтарымыздың еңбегін ел болып әлем деңгейінде насихатталып жатыр. Ел болып мақтананышпен атап өтіп жатқан ұлы іске қарлығыаштың қанатындай су сеуіп, өз үлестерін қосып, тіліміздің айбарын танытқан шәкірттерімізге ақ жол тілейміз. «Өнерлі өрге жүзер» деген батамен ұлы жолға түскен шәкірттеріміз эр сабақта да өздерінің тілдік қасиеттерін, шығармашылық қабілеттерін де көрсетеді. Тіл жүйріктігі байқаған соң, осы шәкірттерді шешендікке негіз болатын нәрсе мақал-мәтелдер, қанатты сөздер, жұмбақтар мен жаңылтпаштардан білім сайысын ұйымдастыруды жоспарладық. «Мың бір мақал, жүз бір жұмбақ» атты сөз сайысына алты турдан тұратын қызықты кеш мазмұнды да, пайдалы болатыны сөзсіз. Мұндағы мақсат та тілдің шұрайлылығын, байлығын көрсететін ұлттық құндылықтарымызды жастардың санасына сіңіру, бойларына дарыту. Өз ұлтының нағыз жанашыр ұландары ең алдымен тілін, салт дәстүрін, мәдениетін, тарихы мен атақты тұлғаларын, бір сөзбен айтқанда руханиятын білуі керек. Оларды ұлықтау керек. Осы бағытта біз шәкірттерімізді шындап, оларды баптап, сынға дайындаймыз. Қанаттары қатайып, ел абыройын асқақатар асыл азаматтардың ізін жалғастырушы ұландарымыз өсіп келеді.

Әл-Фараби атындағы Қазақ Ұлттық университетінің аға оқытушылары Ж.Әділханова, Н.Мужигова, В.Ғабитова